# "НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР" ОНӨААТҮГ-ЫН ЁС ЗҮЙН ДЭД ХОРООНЫ 2023 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙЖ ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖЛЫН ТАЙЛАН (жилийн эцэс)

2023.12.20-ны өдөр

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулах | 01 дүгээр сар | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Ёс зүйн дэд хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг газрын даргаар 2023 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлуулан хэрэгжилтийг ханган ажиллав.  | 100 хувь |

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАТ

НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛИЙН 2023 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны 01 дүгээр сарын 30 — Улаанбаатар хот

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Хариуцах гишүүний нэр, хамтран ажиллах хэлтэс |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 6 | 5 |
| 1 | Ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөө боловсруулан газрын даргаар батлуулах | Зөвлөлийн гишүүд төлөвлөгөөг хуралдаар хэлэлцсэн байна | Төлөвлөгөөг газрын даргаар батлуулна | 01 дүгээр сар | Х.Батхүү |
| 2 | Газрын цахим хуудаст Ёс зүйн цэсийг үүсгэх, мэдээлэл түгээн ажиллах | Ёс зүйн цэсэд байршиж мэдээллийн агуулгыг тодорхойлно | Ёс зүйн дүрэм, Зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө болон бусад мэдээллийг тогтмол байршуулсан байна | Тухай бүр | Ёс зүйн зөвлөл, МТХ |
| 3 | Ёс зүйн дүрмийг өөрчлөлт оруулан шинэчлэн батлуулах | Зөвлөлийн гишүүд дүрэмд оруулах өөрчлөлтийн тухай санал хэлэлцсэн байна | Дүрэм батлан, хэрэгжилтийг хангаж ажилтан, албан хаагчдад танилцуулсан байна | 02 дугаар сар | Зөвлөлийн гишүүд |
| 4 | Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангах шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулах | Дүрэм, журмын талаар мэдлэг олгоно | Дүрэм, журмыг танилцуулан гарын үсгээр баталгаажуулсан байна, газрын хэмжээнд мөрдөж буй дүрэм, журмыг мөрдсөн байна | Тухай бүр | А.Солонго |
| 5 | Албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч бүртгэх | ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийг хүлээн авах үндэслэлийг шалган тогтоох | Ирүүлсэн материалыг шалгаж ёс зүйн зөрчил гаргасан эсэх талаар дүгнэлт гаргасан байна | Тухай бүр | Зөвлөлийн гишүүд |

| № | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Хугацаа | Шалгуур үзүүлэлт | Биелэлт | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 2 | Газрын цахим хуудаст Ёс зүйн цэсийг үүсгэх, мэдээлэл түгээн ажиллах | Тухай бүр | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Газрын цахим хаяг http://invest.ub.gov.mn/-т Ёс зүй нэртэй цэс шинээр үүсгэн зөвлөлийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг тухай бүр нээлттэй байршуулан ажилтнуудад хүргэв.  | 100 хувь |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | | <br><br>Газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/69 дүгээр тушаалаар “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын “Ажилтны ёс зүйн дүрэм”-ийг шинэчлэн батлав. Дүрмийг нийт ажилтнуудад танилцуулан, дотоод сүлжээнд байршуулан ажиллав.<br>Тушаалын хэрэгжилтийг хангаж Ёс зүйн дүрмийн хэм хэмжээг зурагт хуудас бэлтгэн дотоод сүлжээгээр нийт ажилтнуудад хүргэж ажиллаж байна.<br><br><br> | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3 | Ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулан шинэчлэн батлуулах | 02 дугаар сар | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр батлагдсан Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан газрын Ёс зүйн дүрэм шинэчлэх ажил хийгдэнэ. Шинээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг ханган газрын дотоод сүлжээнд хуулийн заалтыг цуврал болгон бэлтгэж тухай бүр байршуулан ажиллаж байна.<br><br><br><br> | 100 хувь |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган шинээр томилогдсон ажилтан, албан хаагчдад байгууллагад мөрдөгдөж буй дүрэм, журмыг танилцуулах | Тухай бүр | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/28 дугаар тушаалаар батлагдсан Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.<br>Дүрмийг http://invest.ub.gov.mn/ сайтад болон газрын мэдээллийн самбарт нээлттэй байршуулав. Мөн дотоод сүлжээгээр дамжуулан дүрмийн хэм хэмжээг цуврал болгон ажилтнуудад хүргэх ажлыг зохион байгуулав.<br><br>Ажилд шинээр томилогдсон 6 албан хаагчид Ёс зүйн дүрмийн хэм хэмжээ болон газарт үйлчилж байгаа дүрэм, журмуудыг танилцуулан танилцуулах хуудсаар баталгаажуулан хувийн хэрэгт хавсаргав.<br><br>ТАНИЛЦУУЛАХ ХУУДАС<br><br>ТАНИЛЦУУЛАХ ХУУДАС | 100 хувь |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | Албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргасан тухай гомдол мэдээллийг цаасан болон цахим хэлбэрээр хүлээн авч бүртгэх | Тухай бүр | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Ёс зүйн зөрчил гаргасан гомдол, мэдээллийг зөвлөлийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр цахим платформ хувилбар болох QR холбоосоор дамжуулан ажилтан, албан хаагчдаас санал, хүсэлт авах ажлыг зохион байгуулав.<br>Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдаас ёс зүйн зөрчлийн талаарх 3 санал ирүүлсэн. Саналыг Ёс зүйн дэд хороо бүртгэлд авч, холбогдох арга хэмжээг авч, санал ирүүлсэн ажилтанд тайлбар хүргүүлэн, зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав.<br>Ёс зүйн дэд хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хангуулан ажилтан, албан хаагчдын ширээний сул талбарт ёс зүйн зөрчлийн талаарх саналыг хүлээн авах QR код байршуулан ажиллаж байна. QR код, цахим хүсэлт авах ажил тогтмолжсон.<br>  | 100 хувь |
| 6 | Ёс зүй, харилцаа хандлагын талаарх судалгааг нийт ажилтан, албан хаагчдаас авч, дүнг нэгтгэн Газрын даргад танилцуулах | 04, 08 дугаар сар | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Газрын дэргэдэх Ёс зүйн дэд хорооны 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгаснаар ажилтнуудын харилцаа хандлага, ёс зүй сэдвийн хүрээнд зөвлөлийн хурлаар 17 асуулга бүхий судалгааг 4 дүгээр сард, нийт албан хаагчдаас цаасан болон цахим хэлбэрээр (цахим платформ буюу QR код) авч нэгтгэв. Судалгааны дүнг Газрын даргад танилцуулан 4 заалт бүхий Зөвлөмж боловсруулан дотоод сүлжээнд байршуулан хэрэгжилтийг ханган ажиллав. | 100 хувь |










Мөн судалгааг төлөвлөгөөний дагуу 09 дүгээр сард нийт 15 асуулт, 2 нээлттэй асуулгын хүрээнд нийт ажилтнуудаас цахим хэлбэрээр (цахим платформ буюу QR код) авсан. Судалгааны дүнг Газрын даргад танилцуулан 5 заалт бүхий Зөвлөмж боловсруулан дотоод сүлжээнд байршуулан хэрэгжилтийг ханган ажиллав.






| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 7 | Ёс зүйн дүрмийн хүрээнд танилцуулга, мэдээлэл түгээх | Тухай бүр | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган http://invest.ub.gov.mn/ сайтын ил тод байдал хэсэгт нээлттэй байршуулав, мөн газрын Мэдээллийн самбарт байршуулан ил тод байдлыг ханган ажиллав.<br><br> | 100 хувь |
| 8 | Газрын мэдээллийн самбар болон хэлтэс өрөөдөд онч мэргэн үгс, зэрэг хандлага стресс тайлах, ажлын бүтээмжээ дээшлүүлэх зурагт хуудас байршуулах, Талархалын аян зохион байгуулах | 03 дугаар сар | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Газрын мэдээллийн самбарт ёс зүйн талаарх зурагт мэдээ, мэдээлэл тайлант хугацаанд нийт 11 удаа шинэчлэн байршуулав.<br><br><br><br><br><br><br>Ёс зүйн дэд хорооны санаачилгаар Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай албыг төлөвшүүлэх, ажиллагсдын ёс зүй, харилцаа хандлагыг төлөвшүүлэх зорилго бүхий “Талархал”-ын аян амжилттай өрнөж, дүнгээ гарган илтгэх хуудсаар баталгаажуулан, газрын сайт болон дотоод сүлжээнд тайлан мэдээ байршуулав<br>Тус аяны хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд.<br>1. Ажлын сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Цагийн менежменттэй-Эртэч ажилтан” шалгаруулах<br>2. Ажилтны ёс зүй, харилцаа, хандлагыг сайжруулах зорилтын хүрээнд “Ёс зүйн гомдол хүлээн авах” | 100 хувь |

3. "Хором бүрийг үнэ цэнэтэй-Үр дүнтэй өнгөрөөцгөөе" зорилтын хүрээнд Уучлалын өдөр
4. "Ёс зүйг эрхэмлэгч хариуцлагатай ажилтан" зорилтын хүрээнд талархлын өдөр
5. Мэдээллийн самбар дахь Ёс зүйн зөвлөл буланд аянтай холбоотой мэдээллийг тухай бүр шинэчлэв.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн Ёс зүйн талаарх зурагт хуудас бүхий мэдээлэл, Төрийн албан хаагчийн Ёс зүйн тухай хуулийн холбогдох заалтын хүрээнд цуврал мэдээлэл бэлтгэн тухайн бүр мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна.





МЭДЭЭЛЭЛ

Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын дэргэдэх "Ёс зүйн зөвлөл", "Ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гомдол, мэдээллийг шийдвэрлэх" чиглэлээр санал, хүсэлтийн **"ХАЙРЦАГ"**-ыг 5 дугаар давхарт цайны өрөөнд байнгын ажиллагаатай байхаар, мөн ажилтан таны ширээний буланд санал, хүсэлт ирүүлэх QR код бүхий зурагт холбоос тус тус байршуулан ажиллаж байна

САНАЛ ХҮСЭЛТ

АЖЛЫН ХЭСЭГ












| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 9 | Удирдлагын Ёс зүйн талаар судалгаа авч, дүнг нэгтгэн Газрын даргад танилцуулах | 9 дүгээр сард | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Мөн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд 9 дүгээр сард газрын удирдах албан тушаалтуудын ёс зүйн, харилцаа, хандлагын талаарх судалгааг авч нэгтгэн, газрын даргад танилцуулан Зөвлөмж боловсруулан удирдлагуудад хүргүүлэн зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж ажиллав.    | 95 хувь |
| 10 | Ёс зүйн мэдээ тайланг Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь хүргүүлэх | Тухай бүр | | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2023 оны 06 дугаар сарын 14-ний өдрийн 03/3755 дугаар албан бичгийн дагуу Ёс зүйн дэд хорооны бүрэлдэхүүн, үйл ажиллагааны тайлан, ёс зүйн зөрчлийн мэдээллийг 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 5/2225 дугаар албан бичгээр хариуг хүргүүлэв.<br>Төлөвлөгөөний биелэлт, тайланг гуравдугаар улирлын байдлаар нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 5/3539 дугаар албан бичгээр хүргүүлэв. Жилийн эцсийн байдлаар 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлэхээр ажиллаж байна. | 100 хувь |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | |  2023.06.19 05/5755<br>НИЙСЛЭЛИЙН НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГУУДАД<br>Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм"-ийн 6 дугаар зүйлд дээрх дүрмийг өөрийн байгууллагын албан хаагчдад мөрдүүлэх, хэрэгжилтийг хангах, тайлагнах чиг үүрэг бүхий Ёс зүйн зөвлөл ажиллана гэж заасан байдаг.<br>Иймд байгууллагын Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагааны тайлан, ёс зүйн сургалтын мэдээллийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны байдлаар хавсралтын маягтын дагуу гаргаж, 2023 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор (цахим хаяг bayarjargal.s@ulaanbaatar.mn хаягаар) ирүүлнэ үү.<br>Хавсралт 3 хуудастай<br>ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ И.БААТАРХҮҮ<br> НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ<br>Тайлан хүргүүлэх тухай<br>Хавсралт 4 хуудастай | |
| 11 | Нэмэлт ажил | 2023.10. 18-ны өдөр | Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь | Дэлхийн ёс зүйн өдрийг тохиолдуулан Ёс зүйн дэд хорооны санаачилгээр УРИАЛГА гарган нийт ажилтнуудад дотоод сүлжээгээр түгээв. Хувь хүний өдөр тутмын амьдралын жижиг шийдвэрээс эхлээд байгууллагын бүхий л төвшний шийдвэр гаргалт, мөн хууль эрх зүй, бодлогын төвшинд "ЁС ЗҮЙН"-н ойлголтыг төлөвшүүлэхэд энэ өдрийн ач холбогдол оршдог. Мөн тогтмол цахим хувилбараар Ёс зүйн зөрчил , ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх чиглэлээр санал хүлээн авч байна.<br> | 100 хувь |
| | | | | **Нийт** | **99,7 хувь** |

ЁС ЗҮЙН ДЭД ХОРОО